

МОНГОЛ, ХЯТАДЫН НҮҮРСНИЙ ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Н.Отгонсайхан

Худалдаа, үйлдвэрлэлийн их сургууль, доктор (PhD)

Товч агуулга: Монгол Улсын гадаад худалдаанд нүүрсний экспорт чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэхүү илтгэлээр дэлхийн нүүрсний зах зээлийн төлөв байдал, Монгол Улсын нүүрсний экспортод БНХАУ-ын эзлэх байр суурь болоод БНХАУ-ын нүүрсний импортын зах зах зээлд Монгол Улсын эзлэх байр суурийн талаар Монгол Улсын гаалийн статистик болон олон улсын худалдааны төвийн статистик мэдээнд үндэслэн судалсан болно.


Түлхүүр үг: Нүүрсний экспорт, нүүрсний импорт, нүүрсний үнэ, нүүрсний зах зээл

1. Дэлхийн нүүрсний зах зээл

1.1. Импорт

Дэлхийн нүүрсний¹ нийт импорт 2018 онд 1225.0 сая тоннд хүрсэн ба 2009 онтой харьцуулахад 257.3 сая тонноор өсчээ. Дэлхийн нийт нүүрсний импортын 80 гаруй хувийг Энэтхэг, Япон, БНХАУ, БНСУ, Тайвань, Герман, Турк, Малайз, Тайланд, Бразил, ОХУ зэрэг ТОП 11 орон эзэлж байна (Зураг 1).

Зураг 1. Дэлхийн нүүрсний импорт, түүнд ТОП 11 орны эзлэх хувь, 2010-2018 он




Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

¹ Монгол Улсын гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээлэлд нүүрсийг “БТКУС-ийн 2701. Чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш” ангиллаар бүртгэсэн тул энэ ангиллын бүтээгдэхүүний талаар судалсан болно.

2018 онд дэлхийн нүүрсний нийт импортод Энэтхэг 18.6% (227.4 сая тонн), Япон 15.5% (189.4 сая тонн), БНХАУ 15.2% (186.4 сая тонн), БНСУ 12.1% (148.7 сая тонн), Тайвань 5.6% (69.2 сая тонн) эзэлж эхний 5 байрт байгаа бол ОХУ 1.8% (22.1 сая тонн) эзэлж 11 дүгээрт оржээ (Зураг 2).

Энэтхэг улс нүүрсний хэрэглээнийхээ 85 хувийг импортоор бүрдүүлдэг бөгөөд 2025 он гэхэд коксжих нүүрсний хамгийн том импортлогч БНХАУ-ыг гүйцнэ хэмээн “Fitch solutions macro research” үзэж байна. Энэтхэгийн нүүрсний импортын зах зээлд Индонез (103.3 сая тонн, хилийн дундаж үнэ 67\$), Австрали (50 сая тонн, хилийн дундаж үнэ 186\$), Өмнөд Африк (34 сая тонн, хилийн дундаж үнэ 90\$) тэргүүлж байна. Эндээс харахад, монгол нүүрс Энэтхэгийн зах зээлд Австралийн өндөр үнэтэй нүүрстэй өрсөлдөх боломж байна.


Зураг 2. Нүүрс импортлогч ТОП 11 орны дэлхийн нүүрсний импортод эзлэх хувийн жин, 2010-2018 он



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Дэлхийн зах зээл дээр нүүрс импортлогч ТОП 10 орны 1 тонн нүүрсний импортын үнийг Зураг 3-т харьцуулан харуулав.

Зураг 3. Нүүрс импортлогч ТОП 10 орны 1 тн нүүрсний импортын хилийн дундаж үнэ, доллар, 2018 он




Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

1.2. Экспорт

Дэлхийн нийт нүүрсний (HS 2701. Чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш) экспортын 90 гаруй хувийг Австрали, Индонез, ОХУ, АНУ, Колумби, Өмнөд Африк, Монгол, Канад, Казакстан, Мозамбик зэрэг ТОП 10 орон эзэлж байна (Зураг 4).

Зураг 4. ТОП 10 орны дэлхийн экспортод эзлэх хувийн жин, %




Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

2018 онд дэлхийн нүүрсний нийт экспортод Австрали 28.6% (382.2 сая тонн), Индонез 25.7% (343.1 сая тонн), ОХУ 14.9% (199.5 сая тонн), АНУ 7.9% (105.4 сая тонн), Колумби 6.3% (83.8 сая тонн) эзэлж эхний 5 байрт байгаа бол Монгол Улс 1.1% (35.8 сая тонн) эзэлж 7 дугаар байрт оржээ (Зураг 5).

Австралийн нүүрсний экспортын зах зээлд Япон (116.8 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 119\$), БНХАУ (87.7 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 114\$), Энэтхэг (48.7 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 153\$), БНСУ (47.8 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 112\$), Тайвань (32.2 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 114\$) тэргүүлж байна. Эндээс харахад, Монгол Улс Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг ашиглан энэ зах зээлд нэвтрэх, мөн Энэтхэгийн зах зээлд үнээр өрсөлдөх боломж өндөр байгаа бөгөөд транзит тээврийн асуудлыг шийдэх шаардлагатай юм. Ингэснээр нүүрсний экспортын зөвхөн нэг орноос хараат байдлыг бууруулах нэг гол гарц байж болох юм.

Зураг 5. Нүүрс экспортлогч ТОП 10 орны дэлхийн нүүрсний экспортод эзлэх хувийн жин, 2010-2018 он




Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Дэлхийн зах зээлд Австрали нүүрсний экспортоор тэргүүлдэг бөгөөд 2011 онд их үер болж, уурхайнууд нь хаагдсанаар экспорт 2010 онтой харьцуулахад 3.3 сая тонноор буурч 24.2 сая тонн болсон. 2012 оны сүүлээр уурхайнууд хэвийн байдалдаа орж 25.2 сая тонн, 2013 онд 26.7 сая тонн нүүрс экспортолсон. 2014 оноос нийлүүлэлтээ эрс нэмэгдүүлж 29.3 сая тонн, 2015, 2016 онд 32 орчим сая тонн нүүрс экспортолжээ. Мөн Австралийн нүүрсний экспортын бууралттай зэрэгцээд Индонез, ОХУ, АНУ зэрэг орнууд нүүрсний нийлүүлэлтээ нэмэгдүүлсэн.

2. Монгол Улсын нүүрсний экспорт

Монгол Улс 2005 онд 7.5 сая тонн нүүрс олборлож, 2.2 сая тонн нүүрс экспортолж байсан бол 5 жилийн хугацаанд огцом өсч 2010 онд нүүрсний олборлолт 3 дахин, экспорт бараг 8 дахин өссөн. Харин 2018 онд 51.4 сая тонн (үүнээс 34.9 сая тонныг хувийн хэвшлийн уурхай) нүүрс олборлож, үүнээс 35.8 сая тонныг нь экспортолсон нь 2005 онтой харьцуулахад олборлолт бараг 7 дахин, экспорт 16 дахин (Зураг 6) нэмэгджээ.

Зураг 6. Монгол Улсын үйлдвэрлэсэн, экспортолсон нүүрс, сая тонн, 2005-2018




Эх сурвалж: Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ГЕГ-ын статистик

2019 онд нийт 36.5 сая тонн чулуун нүүрсийг 3.07 тэрбум ам.доллаароор экспортолсон нь өнгөрсөн онтой харьцуулбал үнийн дүнгээр 288.1 сая ам.доллаароор, тоо хэмжээний хувьд 708.6 мянган тонноор тус тус нэмэгдсэн. Засгийн газар 2019 онд 42 сая тонн нүүрс экспортлохоор төсөөлж байсантай харьцуулахад нүүрсний экспортын бодит дүн бага юм. Хэдий тийм боловч өмнөх жилүүдтэй харьцуулахад урьд өмнө нь байгаагүй өндөр дүнд тооцогдож байна. Оны сүүлийн хоёр сард БНХАУ-ын талын татан авалт буурсантай холбоотой нүүрсний экспорт огцом багассан талаар боомтууд мэдээлсэн. Гэхдээ голлох экспортлогч компаниуд өмнөх оны үзүүлэлтээ давуулсан байна. Тухайлбал: Ховдын Булганы боомтоор нүүрсээ гаргадаг “Mongolia Energy Corporation”-ийн экспорт 70 хувиар өсөж, 1.2 сая тонн болжээ. Боомтоор нь харвал Тавантолгойн бүлэг ордын нүүрсийг гаргаж байгаа Гашуун сухайт боомтоор 20.6 сая тонн нүүрс гаргасан. Голчлон Нарийн сухайтын бүлэг ордоос нүүрс олборлож байгаа компаниуд экспорт хийдэг Шивээ хүрэн боомтын экспорт 12.4 сая тонн хүрчээ¹.


¹ <http://bloombergtv.mn/> 2020.01.13

Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын статистик мэдээлэлд нүүрсийг “БТКУС-ийн 2701. Чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш” ангиллаар бүртгэсэн тул коксжих, эрчим хүчний нүүрсийг ялгах боломжгүй байна. Харин Ашигт малтмал газрын тосны газраас нүүрс олборлогч аж ахуйн нэгжээс тус газарт ирүүлсэн мэдээнд үндэслэн 2015 оноос нүүрсийг Чулуун баяжуулсан коксжих, Чулуун түүхий коксжих, Чулуун сул коксжих, Чулуун эрчим хүчний гэж ялган статистик гаргажээ. Уг статистикаас харахад, Монгол Улс гол төлөв чулуун түүхий коксжих нүүрс экспортолж байна. Тухайлбал, 2019 онд 16.8 сая тонн чулуун түүхий коксжих нүүрс экспортолсон нь нийт нүүрсний 45.6 хувь болжээ (Зураг 7-оос дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү).

Зураг 7. Монгол Улсын экспортолсон нүүрсний төрөл, хувиар, 2015-2019 он



Зураг 8. Монгол Улсын экспортолсон нүүрс, төрлөөр, сая тонн, 2015-2019 он




Эх сурвалж: Ашигт малтмал газрын тосны газрын статистик мэдээ, 2015-2019

Монгол Улс 2005 онд БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, АНУ болон бусад оронд 2.2 сая тонн нүүрс экспортолсноос 99.99 хувь БНХАУ-д ногдож байсан бол 2010 онд дээрх орнуудаас гадна Их Британи, Энэтхэг улсуудад экспорт хийгдсэн ч БНХАУ-д ногдох экспортын хувь 0.09 хувиар л буурсан. 2005-2018 онд нүүрсний нийт экспортын 99.1-99.99 хувь нь зөвхөн БНХАУ-д ногдож нүүрсний экспорт нэг орноос хэт их хамааралтай болсон билээ. 2019 онд нүүрсний нийт экспортын 98 хувийг БНХАУ-д, үлдсэн багахан хэсгийг Их Британи болон Сингапурт гаргажээ.

2016 оноос Монгол Улсаас БНХАУ-д экспортлох нүүрсний хэмжээ эрс нэмэгдэж 25.3 сая тонн (949.2 сая доллар, 1 тонн нүүрсний хилийн дундаж үнэ 37.5\$) болсон нь өмнөх онтой харьцуулахад 55% буюу 11.3 сая тонноор нэмэгдсэн бол 2019 онд 3014.3 сая долларын 35.8 сая тонн нүүрсийг тонн тутмыг дунджаар 84.2 доллароор экспортолсон нь хамгийн оргил үе байлаа. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах зургаас дэлгэрүүлэн үзнэ үү.

Зураг 9. Монгол улсаас БНХАУ-д экспортолсон нүүрс



Эх сурвалж. Монгол Улсын ГЕГ-ын статистик мэдээлэл

Австралид 2011 онд их үер болж, уурхайнууд нь хаагдсанаар БНХАУ-ын зах зээлд Монгол Улсын нүүрс борлогдох үндсэн нөхцөл болжээ. Харин 2012 оны сүүлээр Австралийн уурхайнууд хэвийн байдалдаа орж, нүүрсний нийлүүлэлтээ эрс нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ бусад топ экспортлогчид БНХАУ-ын зах зээлд нүүрсний нийлүүлэлтээ нэмэгдүүлсээр 2013 онд БНХАУ-ын зах зээлд нүүрс илүүдэлтэй болж, эрэлт, нийлүүлэлтийн хуулиар нүүрсний үнэ буурсан гэж үзэж болно.

Монгол Улсын нүүрсний экспорт БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлээс ихээхэн хамааралтай байгаа тул дараагийн хэсэгт энэ зах зээлийн импортын төлөв байдлыг товч авч үзэв.


3. БНХАУ-ын нүүрсний импортын төлөв байдал

БНХАУ нь 2018 онд 19.6 тэрбум долларын 186.4 сая тонн нүүрс импортоор авсан бөгөөд дэлхийн нүүрсний импортын зах зээлийн 15.2 хувийг (Зураг 2) эзэлж Энэтхэг, Японы дараа III байрт орсон. Тус зах зээлд нүүрс экспортолж буй ТОП 10 орныг авч үзэхэд, дэлхийн нүүрсний зах зээлийн гол тоглогч Австрали (43.1%) I байрт, Индонез (20.2%) II байр, Монгол Улс (19.2%) III байрт жагсаж байна. 2010-2012 онд Индонез улс БНХАУ-ын зах зээлд гол экспортлогч буюу нүүрсний нийт импортын зах зээлийн 30-35 хувийг эзэлж байсан бол 2013 оноос Австрали нүүрсний нийлүүлэлтийг эрс нэмэгдүүлснээр 20 хувь болтол буурчээ.

Монгол Улсын нүүрсний экспорт 2016 оноос эрс нэмэгдэж 25.3 сая тонн байсан бол 2018 онд 10 сая тонноор нэмэгдэж 35.4 сая тонн болсноор БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлийн 19 хувийг эзэлсэн. Харин 2019 онд Монгол Улсын нийлүүлэлт нэмэгдсэн ч БНХАУ-ын зах зээлд эзлэх хувийн жин 1 орчим хувиар

буурчээ. Түүнчлэн ОХУ-ын нүүрсний экспорт тогтвортой нэмэгдэж 14-15 хувь болсноор Австрали, Индонезийн дараа манай гол өрсөлдөгч болжээ. Зураг 10-аас дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

Зураг 10. БНХАУ-ын зах зээлд нүүрс экспортолгч
ТОП 5 орон, хувийн жингээр, %




Эх сурвалж. Олон улсын худалдааны төв

ОХУ-ын нүүрсний салбар асар хурдацтай хөгжиж, дэд бүтэц, баяжуулах үйлдвэрүүд нь жилээс жилд хүчирхэгжиж байгаа ба 2018 онд 199.5 сая тонн нүүрс экспортолсон нь 2014 онтой харьцуулахад 46.4 сая тонн, өмнөх онтой харьцуулахад 18 сая тонноор нэмэгдэж дэлхийн нүүрсний зах зээлийн 15 орчим хувийг эзэлсэн бол цаашид 25 хувьд хүргэх зорилттой стратегийн баримт бичиг баталсан.

БНХАУ-ын зах зээлд нүүрс экспортолж буй ТОП 5 орны 2019 оны төлөв байдлыг авч үзэхэд, дэлхийн нүүрсний экспортын зах зээлд Австрали 1 дүгээр байр, Индонез 2, ОХУ 3, Канад 5, Монгол Улс 8 дугаар байрыг тус тус эзэлж байгаа ба Монгол Улсаас бусад 4 орны БНХАУ-д нийлүүлж буй нүүрс нь нийт нүүрсний экспортын 7-17 хувийг (Үүнд Австрали -17%, Индонези - 14%, ОХУ-7%, Канад 15%) л эзэлж байгаа юм. Гэтэл Монгол Улсын нүүрсний нийт экспортын 98 хувь нь зөвхөн БНХАУ-д ногдож байгаа гэдгийг бид мэдэх билээ.


Зураг 11. БНХАУ-ын зах зээлд нүүрс экспортологч орны төлөв байдал, 2019 он



Эх сурвалж. Олон улсын худалдааны төв

2018 онд БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлд 1 тонн нүүрсний¹ хилийн дундаж үнэ 105 доллар байсан бол 2019 онд 96 доллар болж буурчээ. Мөн хугацаанд Канад 179-өөс 177, АНУ 163-аас 141 долларын хилийн дундаж үнээр (зураг 12-оос дэлгэрэнгүй танилцана уу) нүүрс нийлүүлсэн нь хамгийн өндөр үнэ аж.

Зураг 12. БНХАУ-ын нүүрсний импортын хэмжээ, дундаж үнэ ТОП 10 орноор, 2018-2019 он




Эх сурвалж. Олон улсын худалдааны төв

Дээрх зургаас үзэхэд, Монгол Улс 2018 онд 79 доллар буюу БНХАУ-ын импортын зах зээлийн дундаж үнээс 26 долларын доогуур үнээр нүүрсээ нийлүүлж байсан бол 2019 онд 85 доллар болж өссөн. Харин Австрали импортын тарифын хөнгөлөлт эдэлж байгаа хэрнээ Монгол Улсаас 36-50 долларын илүү үнээр БНХАУ-ын зах зээлд нүүрсээ борлуулж байна.

1 БТКУС-ийн 2701. Чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хагуу түлш

БНХАУ-д нүүрс экспортолж буй ТОП 10 орноос зайны хувьд хамгийн ойр нь Монгол Улс бөгөөд манай гол өрсөлдөгч Австрали 8621 км, Индонез 3959 км -ийн зайнаас нүүрсээ тээвэрлэж байгаа юм.

Зураг 13. Нүүрс экспортлогч орнууд болон БНХАУ хоорондын зай, ТОП 10 орноор



Эх сурвалж. Олон улсын худалдааны төв

Түүнчлэн БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлд манай гол өрсөлдөгч болох Австралитай 2015 онд, Шинэ Зеландтай 2008 онд, Вьетнамтай 2014 онд, Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо (ASEAN)-тай 2005 онд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулснаар эдгээр орнууд нүүрсээ БНХАУ-ын зах зээлд “0” тарифтай экспортолж байгаа бол бусад орнуудад ногдуулах дундаж нэн тааламжтай тариф¹ 4.5 хувь байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд бүх орнууд ижил 13 хувийн татвар төлнө. Мөн Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ)-т 2020 онд нэгдэж, 2021 оны 1 дүгээр сарын 1-ээс хэлэлцээрийн заалтыг мөрдөх учраас нүүрсний нэр төрлөөр импортын гаалийн тарифыг судалж дараах зурагт оруулав.

1 Энэ тариф нь БТКУС-ийн 2701 кодтой бүтээгдэхүүний хувьд яригдаж байгаа бөгөөд нүүрсний нэр төрлөөс (БТКУС-ийн үндэсний кодын задаргаа) шалтгаалан 3-6 хувийн импортын гаалийн татвартай байдаг. Монгол Улс БНХАУ-д гол төлөв коксжих нүүрс экспортолж байгаа бөгөөд импортын гаалийн тариф 3 хувь байгаа юм.

Зураг 14. БНХАУ-ын импортын гаалийн тарифын дундаж, ТОП 10 орноор, 2020 он

Экспортлогч орон	Австрали	Индонез	Монгол	ОХУ	Канад	АНУ	Колумби	Казакстан	Вьетнам	Шинэ Зеланд
HS 2701	0% FTA 2015/12/20	0% ASEAN 2005/7/1	4.5%	4.5%	4.5%	4.5%	4.5%	4.5%	0% ASEAN 2005/7/1	0% FTA 2008/10/1

БТКУС/ HS	Барааны нэр	Ердийн тариф	MFN	НӨАТ /VAT	АНДХХ/ APTA	APTA (Эвнэтгэг)	ЭЗТХ/ЕРА (Япон)
270111	Антрацит	20%	3%	13%		50% (MFN 2.5%)	0
27011210	Битумжсан коксжих	20%	3%	13%		50% (MFN 2.5%)	0
27011290	Бусад битумжсан	20%	6%	13%		50% (MFN 2.5%)	0
270119	Бусад	20%	5%	13%	30%	50% (MFN 2.5%)	0
270120	Чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон элгээртэй төстэй хатуу түлш	50%	5%	13%		45% (MFN 2.5%)	0

Эх сурвалж. Олон улсын худалдааны төв

Тайлбар: MFN -нэн тааламжтай тариф, FTA - Чөлөөт худалдааны хэлэлцээр, ASEAN-Зүүн өмнөд азийн орнуудын холбоо, БТКУС/HS- Барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем, АНДХХ/APTA- Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр, ЭЗТХ/ЕРА-Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, НӨАТ/VAT-Нэмэгдсэн өртгийн албан татвар.

Дээрх нөхцөл байдлаас харахад Австрали, Индонез зэрэг манай гол өрсөлдөгчид нүүрсний үнийг бууруулах, эсхүл илүү ашиг олох боломжтой нь харагдаж байна. Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй битумжсан коксжих нүүрс АНДХХ-ийн хүрээнд хөнгөлөлт эдлэхгүй ба Энэтхэг улсад экспорт хийсэн тохиолдолд нэн тааламжтай тарифаас 50 хувийн хөнгөлөлт (5%-2.5%) эдлэх, харин Японтой байгуулсан ЭЗТХ-ийн хүрээнд гаалийн тариф “0” байгаа юм.

Дүгнэлт санал

Дэлхийн нүүрсний импортын зах зээлд хэрэглээнийхээ 85 орчим хувийг импортоор бүрдүүлдэг Энэтхэг улс тэргүүлж байгаа бөгөөд 2025 он гэхэд коксжих нүүрсний хамгийн том импортлогч болох ажээ. Тиймээс монгол нүүрс Энэтхэгийн зах зээлд Австралийн өндөр үнэтэй (хилийн дундаж үнэ 186\$) нүүрстэй өрсөлдөх боломж байна.

Дэлхийн нүүрсний экспортын зах зээлд Австрали, Индонез, ОХУ тэргүүлж байгаа бөгөөд Монгол Улс ТОП 10 оронд ордог. Монгол Улс Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг ашиглан энэ зах зээлд нэвтрэх, Энэтхэгийн зах зээлд хямд үнээр өрсөлдөх боломж өндөр байгаа учраас транзит тээврийн асуудлыг шийдэх нь чухал байна. Ингэснээр нүүрсний экспортын хувьд зөвхөн нэг орноос хараат байдлыг бууруулах нэг гол гарц байж

болох юм.

Монгол Улсын нүүрсний экспорт 2015 оноос тасралтгүй өсч байгаа хэдий ч бараг 100 хувь БНХАУ-д экспортолж байгаа нь энэ улсын нүүрсний импортын зах зээлээс хараат боллоо. Гэтэл БНХАУ-ын зах зээлд нүүрс экспортолж буй ТОП 5 орны 2019 оны статистикээс үзэхэд, Австрали нүүрсний нийт экспортынхоо 17%, Индонези 14%, ОХУ 7%, Канад 15%-ийг л Хятад улсад экспортолж байна. Монгол Улс БНХАУ-ын нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдлыг нүүрсний нэр төрөл бүрээр байнга ажиглах, нөгөө талаас нүүрсний экспортын зах зээлийг өргөжүүлэхэд шаардлагатай бүхий л боломжийг хайх хэрэгтэй.

БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлд Монгол Улс 2010 онд 16.6 сая тонн нүүрс экспортолж, импортын зах зээлийн 10 орчим хувийг эзэлж байсан бол 10 жилийн хугацаанд буюу 2019 онд 36.6 сая тонн экспорт хийж, зах зээлд эзлэх хувь 18.3 болж өссөн.

2019 оны байдлаар БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлийн 39 хувийг Австрали, 24.3 хувийг Индонез, 18.3 хувийг Монгол Улс, 14.8 хувийг ОХУ эзэлж эхний байрыг эзэлж байгаа ба хилийн дундаж үнэ нь дээрх орнуудын хувьд тус тус 121, 62, 85, 87 доллар байгаа ба ОХУ-аас БНХАУ-д экспортлох нүүрсний хэмжээ тогтвортой нэмэгдэж манай гол өрсөлдөгч болох магадлал өндөр байна.

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд БНХАУ-ын нүүрсний гаалийн тарифыг бууруулах асуудлыг дараагийн буюу 6 дугаар үе шатанд тавьж шийдвэрлүүлэх, ингэхдээ Монгол Улсын нүүрсний нөөц, БТКУС-ийн кодыг анхааралдаа авах шаардлагатай.

Монгол Улс Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай Ерөнхий хэлэлцээрт нэгдэж цаасгүй худалдааны чиглэлээр шинээр гарч буй стандарт, шийдлийг хугацаа алдахгүй турших, чадавхийг бэхжүүлэх замаар худалдааг хөнгөвчлөх, худалдааны хэлцлүүдийг илүү үр ашигтай, ил тод болгох нь зүйтэй боловуу.

Ашигласан материал

Монгол Улсын гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээлэл, 2019

Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Ашигт малтмал газрын тосны газрын нүүрсний мэдээлэл

Олон улсын худалдааны төвийн статистик мэдээлэл

БНХАУ-ын гаалийн тарифын мэдээлэл

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн үндэсний тарифын хөнгөлөлтийн жагсаалт (БНХАУ, Энэтхэг)

Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай Ерөнхий хэлэлцээр

Монгол-Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр

<http://bloombergtv.mn/> 2020.01.13